

Шашны семинар ба институтийн зорилго

Өсвөр үеийнхэн болон залуучуудыг Есүс Христийн сургаал ба Цагаатгалыг ойлгон, үүнд найдаж, Ариун сүмийн адислалуудыг хүлээн авахад зохистой байж, өөрсдийгөө болон гэр бүлээ түүнчлэн бусдыг Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт байх мөнхийн амьдралд бэлтгэхэд нь туслахад бидний зорилго оршдог.

Зорилгодоо хүрэхийн тулд:

Амьдрах

Бид Есүс Христийн сайн мэдээгээр амьдарч, Сүнсний нөхөрлөлийг эрэлхийлдэг. Бидний биеэ авч явах байдал болон зан харьцаа нь гэр орон, анги танхим мөн нийгэмд үлгэр жишээ болдог. Бид амжилт, мэдлэг, хандлага болон зан төлөвөө үргэлж сайжруулахыг хичээдэг.

Заах

Бид суралцагсаддаа сайн мэдээний сургаал ба зарчмуудыг бошиглогчдын болон судрууд дээр байгаагаар нь заадаг. Энэхүү сургаал болон зарчмуудыг ойлгох мөн сэнхрэхэд нь чиглүүлэн заадаг. Бид суралцагсаддаа суралцах явцад нь тэднийг өөрсдийн үүргээ биелүүлэхэд нь тусалдаг ба сайн мэдээг бусдад заахад нь бэлтгэдэг.



Удирдах

Бид хөтөлбөр болон нөөц бололцоогоо зохистойгоор зохион байгуулдаг. Бидний хүчин зүтгэл эцэг эхчүүдэд гэр бүлээ хүчирхэгжүүлэхэд нь тусалдаг. Бид суралцагсаддаа хамтдаа суралцан нөхөрлөх сүнслэг орчинг бүрдүүлэхийн тулд санваартны удирдагчидтай нягт холбоотой ажилладаг.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ